

ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 6 сарын 04-ний өдөр

№ 20/24

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргах өрийн бичгийн хэмжээг тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн 20/17 тогтоол, 2020 оны 6 сарын 04-ний өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-иас нийтэд санал болгон гаргах өрийн бичгийн хэмжээг 5.0 (таван) тэрбум төгрөгөөр тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн №306 тоот тогтоолоор Компанийн хаалттай хүрээнд санал болгох 7.4 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээс 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар гаргаагүй 4.0 (дөрвөн) тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичгийг Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт цаасны бүртгэлээс хасуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын дагуу нийтэд санал болгон гаргах өрийн бичгийг бүртгүүлэх, нийтэд санал болгон гаргах, хаалттай өрийн бичгийн бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэх, хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т даалгасугай.

